



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/62

Хэрлэн сум

Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан
хаалгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2009 оны 33, Засгийн газрын 2017 оны 51 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2017 оны цэрэг, техникийн тоо бүртгэлээр цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, энэ захирамжийн хавсралтад нэр заасан залуучуудаар цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгасугай.

Хоёр. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах залуучуудын цэргийн жинхэнэ албаны татлагад хамрагдаагүй, чөлөөлөгдсөн үндэслэлийг харгалзан мөнгөн төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх хугацаа тогтоож, хүн бүрт мэдэгдэх хуудас хүргүүлэхийг Цэргийн штабын дарга /дэд хурандаа Н.Хүрэлээ/-д үүрэг болгосугай.

Гурав. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан залуучуудаар төлбөрийг заасан хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг хагас бүтэн жилээр ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, төлбөр төлсөн тухай тэмдэглэлийг цэргийн үүрэгтний үнэмлэхэд нь бичиж баталгаажуулахыг Цэргийн штабын дарга /дэд хурандаа Н.Хүрэлээ/, Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 374